



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2025 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 172

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад заасан 1 /нэг/ хуулийн этгээдэд "Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх" тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгосугай.
2. Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр хүлээн авсан этгээд түүнийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдтэй зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД

Б.АНХБААТАР


Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн
172 тоот тогтоолын
хавсралт



Тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн
жагсаалт

№	Хуулийн этгээдийн нэр	Хамрах хүрээ, Үйлчилгээний хүртээмж	Олгосон дугаар	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа
1	Телко ХХК	Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх (Хот, хот хоорондын ярианы үйлчилгээ/ суурин)	7911-xxxx 7910-xxxx 7909-xxxx 7900-xxxx	2025.08.19	2030.08.19

----- оОо -----